



Co-funded by the  
Erasmus+ Programme  
of the European Union



## THE MEMORANDUM OF UNDERSTANDING OF COLLABORATION BETWEEN THE UNIVERSITIES ON THE INTENSE NATIONAL DOCTORAL PROGRAM

Title:	Integrated doctoral program for environmental policy, management and technology - INTENSE
Number:	586471-EPP-1-2017-1-EE-EPPKA2-CBHE-JP
Participants:	National University of Mongolia – NUM Khovd State University – KhU Mongolian University of Life Sciences – MULS
Date	2021.04.23
Place	Ulaanbaatar city

### Background information:

Presidents of six public universities of Mongolia have been signed on general MoU to university strengthening, human development, joint research and education on 18<sup>th</sup> December 2020. Attachment.

1. Mongolian National University of Medical Sciences
2. National University of Mongolia
3. Mongolian University of Life Sciences
4. Mongolian State University of Education
5. Mongolian University of Science and Technology
6. Mongolian State University of Arts and Culture

In scope of this MoU, NUM has invited MULS to join the INTENSE national doctoral program for strengthening the quality of doctoral training in the field of environment, sustainability and extension of the program.

### The objective of the meeting:

The objective of this MoU is to collaborate on the INTENSE national doctoral program in Mongolia.

### Participants:

- ~ Professor O.Altansukh, Department of Environment and Forest Engineering, NUM
- ~ Professor B.Bayarhuu, Department of Geography and Geology, KhU
- ~ Professor D.Delgerjargal, Department of Horticulture, Forestry, and Landscape Architecture, MULS

### Issues discussed:

Opportunities to collaborate amongst National University of Mongolia, Khovd State University, and Mongolian University of Life Sciences within the framework of INTENSE national doctoral program, including joint research, joint PhD supervision, shared e-learning and shared research facilities.

**Decisions and future activities planned:**

The following decision and action points have been agreed by the partners.

- ~ NUM, KhU, MULS will collaborate on the INTENSE national doctoral program, based on general MoU between universities (2020-12-18) and on the Agreement on the Establishment of the National Doctoral School INTENSE signed by its founding members – NUM and KhU (2019-04-26). Collaboration will focus on joint research and education.

In this collaboration, the following activities will be organized.

- ~ Joint Quality Assurance arrangements, such as mutual curriculum review between MULS, NUM and KHU/
- ~ A 2 weeks summer school in Khovd aimag in 2021 and joint organization of training events in the future.
- ~ Organize joint research seminar /3-4 professors from each university will present their research findings during an online seminar, which will be organized monthly in 2021 and kept in the future/
- ~ During the summer school – 2021 we will create demo version of E-field study and jointly explore it in future activities.

**Parties agreed:**

Professor O.Altansukh, National University of Mongolia



Professor B.Bayarhuu, Khovd State University



Professor D.Delgerjargal, Mongolian University of Life Sciences



## Appendix 1: General MoU

### ТӨРИЙН ӨМЧИЙН ИХ СУРГУУЛИУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2020 оны 12 дүгээр сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 12 зүйлийн 12.1.11 дэхь заалт, бусад хуульд заасан эрх, үүргийг үндэслэн төрийн өмчийн их сургуулиудыг төлөөлж АШУҮИС-ийн захирал доктор, профессор Н.Хүрэлбаатар, МУИС-ийн захирал доктор, профессор Б.Очирхуяг, ХААИС-ийн захирал доктор, профессор Т.Хэрүүга, МУБИС-ийн захирал доктор Д.Мандах, ШУТИС-ийн захирал доктор, профессор Б.Очирбат, СУИС-ийн захирал доктор, профессор Э.Сонинтогос нар (цаашид “Талууд” гэх) харилцан тохиролцож энэхүү санамж бичгийг байгуулав. Санамж бичигт талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш таван жилийн хугацаанд хүчинтэй байна.

#### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү санамж бичгийн зорилго нь талууд хөгжлийн бүхий л асуудлаар мэдээлэл, туршлага солилцож харилцан суралцах, хамтран ажиллах чиглэлийг тодорхойлж, төрийн өмчит их сургуулиуд хамтдаа хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэхэд оршино.
- 1.2 Талууд хамтран ажиллахдаа холбогдох хууль эрх зүйн хүрээнд, их сургуулиудын онцлог, үнэт зүйл, уламжлал соёлыг эрхэмлэн, эрх тэгш, нээлттэй, ил тод санал солилцон зөвшилцөх зарчмаар шийдвэр гаргаж ажиллана.
- 1.3 Санамж бичгийн хүрээнд гарах шийдвэр, үйл ажиллагааг зохицуулах төрийн өмчийн их сургуулиудын захирлуудын зөвлөлтэй байна.

#### Хоёр. Үйл ажиллагааны чиглэл

- 2.1 **Дээд боловсролын хууль эрх зүй, их сургуулиудын хөгжлийн бодлогын талаар;**
  - 2.1.1 Дээд боловсрол, их сургуулийн хууль эрх зүйн шинэчлэл, хөгжлийн бодлого, үзэл баримтлалыг тодорхойлоход талууд нэгдмэл байр суурьтай оролцох
  - 2.1.2 Талууд их сургуулийн дүрэм, эрх зүйн баримт бичгүүдийн бүтэц, агуулгыг жишиг загварт оруулж, боловсронгуй болгох

2.1.3 Монгол улсад Судалгааны их сургуулийн тогтолцоог бий болгох, хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах

**2.2 Хүний нөөц, багш, оюутны хөгжлийн бодлогын талаар;**

2.2.1 Талууд багш хөгжүүлэх нэгдсэн хөтөлбөрийг хамтран боловсруулан хэрэгжүүлж, багшлах хүний нөөцийг чадавхжуулах

2.2.2 Багшийн үйл ажиллагааг нэгдсэн аргачлалаар үнэлдэг журмыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх

2.2.3 Оюутан залуусыг эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, үндэсний хэл, түүх, соёл, уламжлалаа эрхэмлэн дээдлэгч, хариуцлагатай “Монгол Иргэн” болгон төлөвшүүлэхэд хамтран ажиллах

**2.3 Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаар**

2.3.1 Тухайн их сургуулийн хүний нөөц, тоног төхөөрөмжийн давуу тал, чадавхит түшиглэн эрдэм шинжилгээ судалгааны лаборатори, төвүүдийг байгуулж, салбар дундын судалгаа, төсөл, хөтөлбөрийг боловсруулж, хамтран хэрэгжүүлэх

2.3.2 Талууд “Эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн цахим сан” байгуулж, номын сангаа хамтран ашиглах эрх зүйн орчин бүрдүүлэх

2.3.3 Талууд Шинжлэх ухаан – техник – технологи – инноваци - үйлдвэрлэлийг уялдуулан хамтран ажиллаж, Монгол Улсын нийгэм, эдийн засагт үзүүлэх өгөөжийг нэмэгдүүлэх

**2.4 Сургалтын үйл ажиллагааны талаар;**

2.4.1 Ерөнхий мэргэжлийн хичээлүүдийг нэгдсэн хөтөлбөртэй болгож, багц цагийг дүйцүүлэх, сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах

2.4.2 Талууд суурь болон мэргэжлийн хичээлүүдийн агуулгыг дахин үнэлж, цөм хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх

2.4.3 Эрдэм шинжилгээ, сургалт, мэргэжлийн үйл ажиллагаагаандаа цахим технологи нэвтрүүлэх чиглэлээр талууд хамтран ажиллах

2.4.4 Талууд оюутныг их сургуулиуд хооронд хичээл сонгон суралцах боломжийг бүрдүүлж ажиллах

**Гурав. Бусад**

3.1 Талууд онцгой байдал, цар тахал (КОВИД-19) -ын үед бодлого, үйл ажиллагаагаа нэгтгэн, эрдэм шинжилгээ судалгаа, төсөл хөтөлбөр, үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх



- 3.2 Талууд оюутны сургалтын төлбөрийн асуудлаар нэгдмэл байр суурь баримтлах
- 3.3 Эрдэмтэн багш, ажилтан, албан хаагч, суралцагсдад эрүүл мэндийн боловсрол олгох, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах талаар хамтран ажиллах
- 3.4 Шинжлэх ухаан, танин мэдэхүйн бүтээл, эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнг нийтэд түгээн дэлгэрүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлээр талууд хамтран ажиллах

**САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН**

АШУУИС-ийг төлөөлж захирал  
Профессор Н.Хүрэлбаатар




МУИС-ийг төлөөлж захирал  
Профессор Б.Очирхуяг



ХААИС-ийг төлөөлж захирал  
Профессор Т.Хэрүүга




МУБИС-ийг төлөөлж захирал  
Доктор Д.Мандах



ШУТИС-ийг төлөөлж захирал  
Профессор Б.Очирбат



СУИС-ийг төлөөлж захирал  
Профессор Э.Сонинтогос



**Appendix 2: Agreement on the INTENSE national program**



**ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО, МЕНЕЖМЕНТ, ТЕХНОЛОГИЙН АХИСАН ТҮВШНИЙ INTENSE ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2019 оны 04 сарын 26-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Нэг талаас Монгол Улсын Их Сургууль (цаашид МУИС гэх), түүнийг төлөөлж Дэд захирал Б.Очирхуяг, нөгөө талаас Ховд Их Сургууль (цаашид ХИС гэх), түүнийг төлөөлж Дэд захирал О.Мөнхжаргал нарын хооронд Европын Холбооны Erasmus+ хөтөлбөрийн Дээд боловсролын чадавхыг бэхжүүлэх нь 2-р үйл ажиллагааны хүрээнд тус хоёр их сургуулиудад хэрэгжиж буй Хүрээлэн буй орчны бодлого, менежмент, технологийн ахисан түвшний INTENSE хөтөлбөрийг Монгол улсад нутагшуулан хэрэгжүүлэх зорилгоор харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2. Талууд хамтын ажиллагаандаа хуулийг дээдлэх, харилцан бие биеэ хүндэтгэх, байгууллагуудын хоорондын харилцааны хэм хэмжээнд үндэслэн бүтээлчээр хамтран ажиллах зарчмыг баримтална.
- 1.3. Гэрээний үндсэн чиглэлүүдээр тодорхой ажлуудыг гүйцэтгэхэд тухай бүр харилцан тохиролцох замаар гэрээ байгуулан гүйцэтгэнэ.

**Хоёр. Гэрээний зорилго**

- 2.1. Хүрээлэн буй орчны бодлого, менежмент, технологийн ахисан түвшний INTENSE хөтөлбөрийг Монгол улсад нутагшуулан хэрэгжүүлэх, зайн сургалтын хичээлүүдийг бэлтгэх, ахисан түвшний хамтарсан, зайн сургалтын хөтөлбөрийг боловсруулахад энэхүү гэрээний зорилго оршино.

**Гурав. Талуудын нийтлэг үүрэг**

- 3.1. МУИС болон ХИС нь дараах эрх, үүргийг харилцан тэгш хүлээнэ.
  - 3.1.1. Хүрээлэн буй орчны бодлого, менежмент, технологийн ахисан түвшний (магистр, доктор) хамтарсан зайн сургалтын сургалтын хөтөлбөрийг бий болгож, хэрэгжүүлэх,
  - 3.1.2. Талууд өөрсдийн санал болгосон зайн сургалтын хичээл, хөтөлбөрийг өөрсдийн хүний нөөц, техникийн боломж дээр тулгуурлан тогтоосон цаг хугацаанд хийж гүйцэтгэх,
  - 3.1.3. Талууд зайн сургалтын материал бэлтгэх, түүнийг интернэт орчинд байршуулж, олон нийтэд түгээхэд харилцан биедээ хүний нөөц болон техникийн туслалцааг үзүүлж болох бөгөөд үүнийг тусдаа гэрээгээр зохицуулах,
  - 3.1.4. Зайн сургалтын дотоод журмыг хамтран боловсруулж, Талууд хамтран батлах,

3.1.5. Зайн сургалтаар олгогдох багшийн болон оюутны багц цагийн асуудлыг өөрсдийн дотоод журмын хүрээнд зохицуулах, эс бөгөөс харилцан тохиролцож, түүнийгээ баталгаажуулах,

3.1.6. Хамтарсан зайн сургалтыг амжилттай дүүргэсэн төгсөгчдөд олгох эрдмийн зэрэг, диплом, түүний нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх асуудлаар тусдаа ажлын хэсэг байгуулж, шийдвэрлэх,

**Дөрөв. Гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, дүгнэх**

- 4.1. Гэрээг хэрэгжүүлэх талаар Талууд жил бүрийн эхэнд төлөвлөгөө гарган баталж, ажиллана.
- 4.2. Гэрээнд заагдсан ажлын явц, хэрэгжүүлсэн ажлын үр дүн, хөрөнгийн зарцуулалтыг жил бүр хэлэлцэж байна.
- 4.3. Гэрээний талууд хамтын ажиллагааны гэрээнд заагдсан ажлыг хэрэгжүүлэхдээ тэгш оролцоог хангана.
- 4.4. Аль нэг талын тавьсан санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж, ажлын гүйцэтгэлийг сайжруулах талаар гаргасан шаардлага, ажлын явцын мэдээллийг Талууд хамтран хэлэлцэнэ.
- 4.5. Гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Талууд хамтын хяналт тавина.
- 4.6. Гэрээг хэрэгжүүлэх үүргийг Талуудын төлөөлөгчид биечлэн хариуцах бөгөөд МУИС-ийг төлөөлөн Хэрэглээний Шинжлэх Ухаан, Инженерчлэлийн Сургуулийн Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхимийн профессор О.Алтансүх, ХИС-ийг төлөөлөн Байгаль Шинжлэл, Технологийн Сургуулийн Газарзүй-Геологийн тэнхимийн профессор Б.Баярхүү нар байна. Төлөөлөгчдийн ажлыг үнэлэх асуудлыг Талууд өөрсдийн дотоод дүрэм, журмаараа зохицуулна.

**Тав. Гэрээ хүчин төгөлдөр болох, гэрээний хугацаа**

- 5.1. Талуудын эрх бүхий төлөөлөл гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.
- 5.2. Талууд харилцан тохиролцож, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 5.3. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд, түүнчлэн гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 5.4. Гэрээний хугацаа 5 жил байх бөгөөд аль нэг тал цуцлах санал бичгээр гаргаагүй тохиолдолд дахин 5 жилээр сунгасанд тооцно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

ХШУИС-ийн Хүрээлэн буй орчин,  
ойн инженерчлэлийн тэнхимийн  
профессор О.Алтансүх

.....

Огноо: 2019-04-26



БШТС-ийн  
Газарзүй-Геологийн Тэнхимийн  
профессор Б.Баярхүү

.....

Огноо: 2019-04-26

